



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА
ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН УДИРДЛАГА
СУДЛААЧ ТАНАА

SPSIRPA FORUM 2024

“Геополитикийн дахин хуваарилалт: Бүс нутгийн тулгамдсан асуудлууд ба төрийн бодлого”

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын удирдамж

Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлал, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль (УТСОУХНУС)-иас жил бүр зохион байгуулагддаг “SPSIRPA FORUM” олон улсын эрдэм шинжилгээний хурал нь дэлхийн улс үндэстнүүдийн цаг үеийн тулгамдсан асуудлуудын талаар эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүн, дүгнэлтүүдийг хэлэлцдэг өндөр ач холбогдолтой арга хэмжээ байсаар ирсэн.

Өнөөгийн олон улсын харилцаанд оролцогч улс үндэстнүүдийн өрсөлдөөн улам бүр нэмэгдэж, олон улсын эрх зүйн хэм хэмжээнд шинэ сорилт тулгарч дэлхий дахин, бүс нутагт амаргүй нөхцөл байдал бий болж буйтай уялдуулан нийгэм, улс төр, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж ажиллах нь дэлхийн улсуудын хувьд ухаалгаар даван туулах асуудал болоод байна.

Бид энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлын үеэр Та бүхний олон жилийн нөр их хөдөлмөр шингэсэн судалгаа шинжилгээнд суурилсан дүн шинжилгээ, санал зөвлөмжинд онцгойлон анхаарал хандуулж, улс төр, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын тулгамдсан асуудлуудаар эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн судалгаа, шинжилгээнд суурилсан шинэ санаа бүхий илтгэлүүдийг хэлэлцүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Та бүхний хэлэлцүүлсэн илтгэлүүд олон улсын болон нийгмийн тулгамдсан олон асуудалд шийдэл болох нь дамжиггүй юм.

“SPSIRPA FORUM”-2024 нь аливаа шийдэл боломжийг эрэлхийлэгч олон улсын эрдэмтэн судлаач, бодлого боловсруулагчдын хуралдаан юм. Энэ удаагийн форум 2024 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Монгол улсын их сургуулийн УТСОУХНУС-дээр 8 дахь жилдээ зохион байгуулагдах гэж байна.

Энэ удаагийн форумын зорилго нь үндэсний болон олон улсын эрдэмтэн судлаачдын оролцоог хангаж, дэлхийн улс орны хөгжилд тулгарч буй сорилт, дэлхийн шинэ дэг журам,

геополитик болон бүс нутгийн нөхцөл байдлын цаашдын чиг хандлагын тухай олон асуудлыг мэргэжлийн түвшинд хөндөж, шийдвэрлэх арга зам, санал зөвлөмжийг өргөн хүрээнд хэлэлцүүлэх бөгөөд гадаад, дотоод бодлогын тогтвортой байдлыг хангах, шийдвэр гаргах түвшинд хүргэх юм.

Ерөнхий зохион байгуулагч:

- МУИС- УТСОУХНУС
- Хамтран зохион байгуулагч:
- ШУА-Олон улс судлалын хүрээлэн
- Монгол улсын Боловсролын их сургууль
- Монгол улсын Дотоод хэргийн их сургууль
- Отгон тэнгэр Их сургууль

Хамрах хүрээ:

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй холбогдох салбар их дээд сургууль, Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, салбарын яамд, тамгын газар, Гадаад улсаас Монгол улсад суух элчин сайдын яамд, Олон улсын их дээд сургуулиуд, Олон улсын эрдэмтэн судлаачид.

Хугацаа:

2024 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд МУИС-ийн УТСОУХНУС болон МУИС-ийн номын сан

SPSIRPA FORUM 2024 эрдэм шинжилгээний хуралд оролцох эрдэмтэн, судлаач, багш, докторантууд илтгэлийн сэдэв, хураангуйгаа 2024 оны 03-р сарын 15-ны дотор ирүүлэх

Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Батцэцэг

battsetseg.a@num.edu.mn хаягаар ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ



С.МӨНХБАТ

SPSIRPA FORUM 2024 – “Геополитикийн дахин хуваарилалт: Бүс нутгийн тулгамдсан асуудлууд ба төрийн бодлого”

Ерөнхий зохион байгуулагч:

МУИС-Улс төр судлал, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль

Хамтрн зохион байгуулагч:

ШУА-Олон улс судлалын хүрээлэн

Монгол улсын Боловсролын их сургууль

Монгол улсын Дотоод хэргийн их сургууль

Отгон тэнгэр Их сургууль

Хурлын тов:

- Хурал болох огноо: 2024.05.24-25 (Баасан, Бямба гараг)
- Илтгэлийн сэдэв, хураангуй хүлээн авах сүүлийн хугацаа: 2024.03.10
- Илтгэлийг бүрэн эхээр нь хүлээн авах сүүлийн хугацаа: 2024.04.25

Салбар хуралдааны тухайд:

Салбарын тэнхимийн эрхлэгч нартай холбогдоно уу.

Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч. Профессор Ж.Төртогтох.

цахим хаяг: turo@num.edu.mn

Олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч. Дэд Профессор С.Баясгалан

Цахим хаяг: bayasgalan@num.edu.mn

Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлэгч. Дэд Профессор Г.Баасанжав

Цахим хаяг: baasanjav_ue@num.edu.mn

Хаана: МУИС-ийн номын сан болон онлайнаар.

Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх өгүүлэл нь судалгаанд суурилсан, шинэлэг санал санаачилга дэвшүүлсэн, нотолгоо сайтай, техник шаардлагыг хангасан байна.

Жич: Илтгэлд тавигдах шаардлага:

- Бүтэц
Өгүүллийн нэр, зохиогчийн товч мэдээлэл, товчлол, түлхүүр үг, үндсэн өгүүлэл, номзүй.
- Өгүүллийн нэр
Монгол, англи хэлээр, том үсгээр бичсэн байна.
- Хураангуй
Өгүүллийг монгол, англи хэлний аль нэгээр бичнэ. Өгүүллийн хураангуй англи хэл дээр байна.
- Эшлэл, зүүлт, ном зүй
АРА журмыг баримтлана.
- Өгүүллийн хэмжээ
А4 хэмжээтэй 8-12 нүүр байна. (Хуудсыг дугаарлана).